



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 709

Улаанбаатар хот

Г Авлага, өглөгийг данснаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газартай холбоотой 2007 онд үүссэн, 13,080,236,150.0 /арван гурван тэрбум наян сая хоёр зуун гучин зургаан мянга нэг зуун тавин/ төгрөгийн авлагыг найдваргүй авлагад тооцож данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газартай холбоотой 2007 онд үүссэн, 13,080,236,150.00 /арван гурван тэрбум наян сая хоёр зуун гучин зургаан мянга нэг зуун тавин/ төгрөгийн өглөгийг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

3. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбат нар дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Авлага, өглөгийг үйлдвэрийн газрын данснаас хасах асуудлыг НББОУСтандарт, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

3.2. Тогтоолын биелэлтийг 2021 оны нэгдүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс /Ц.Баяр-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

ДАРГА   
Б.ЦЭНГЭЛ

ДАРГА   
Ц.БАЯР-ЭРДЭНЭ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА